

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны
05 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит бус XII
хуралдааны 12/08 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН "БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ"

НЭГ. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмын зорилго: Бэлчээрийг нөөц, даацад нь тохируулан зохистой ашиглаж, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглалтыг экологийн чадавхад суурилсан аргачлалаар төлөвлөх, уг төлөвлөгөөний дагуу улирлын хуваарьтайгаар зүй зохистой ашиглаж, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын нутгийн удирдлага, малчид, нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг дагаж мөрдөх: Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, өвөлжөө, хаваржааны бэлчээр, хадлангийн талбайг тодорхой хугацаанд малын хөлөөс чөлөөлөх зэрэг бэлчээрийг зүй зохистой ашиглаж улирлын хуваарьтай хамгаалахад малчид, мал бүхий иргэд бэлчээр ашиглагчдын хэсэг, бүлэг, нөхөрлөл, аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд энэхүү журмыг мөрдлөгө болгон ажиллана.

1.3. Журмыг хэрэгжүүлэх: Журмын хэрэгжилтийг сумын Засаг дарга удирдлага зохион байгуулалтаар хангаж, холбогдох мэргэжилтэнгүүд болон багийн Засаг дарга нар хариуцан гүйцэтгэнэ.

1.3.1. Сумын Засаг даргын захирамжаар оны эхэнд сумын Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг томилон, хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг хагас бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллана. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг "Төсвийн тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасны дагуу сумын орон нутгийн хөгжлийн санд жил бүр тусгана.

ХОЁР. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх:

2.1. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийг улирлаар ашиглах, зун, намрын бэлчээрийг сар, улирлаар сэлгэх, ашиглах, өнжөөх, хуваарь, отор нүүдэл хийх, худаг ус гаргах, засварлах, хадлангийн талбайг ашиглах, хамгаалах, сайжруулах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх, доройтсон бэлчээрийг сайжруулах, тэжээл тариалах, зэрлэг амьтны бэлчээрийг хамгаалах зэрэг арга хэмжээнүүд орно.

2.2. Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална:

2.2.1. Бэлчээрийн экологийн чадавхад суурилах;

2.2.2. Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

2.3. Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид "Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө" гэх) нь дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1. Бэлчээрийн төлөв байдал, чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ (цаашид "фотомониторинг" гэх)-ний дүн, бусад мэргэжлийн байгууллагуудын судалгаанд үндэслэгдсэн байх;

2.3.2. Бэлчээрийн улирлын болон богино хугацааны сэлгээ, отор нүүдэл хийх хуваарийг нөхөрлөл, Бэлчээр ашиглагчдын хэсэг, баг тус бүрээр гаргасан байх;

2.3.3. Бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах замаар байгалийн жамаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн байх;

2.3.4. Бэлчээрийн ургац сайтай хэсгээс хадлан бэлтгэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцлийг бүрдүүлсэн байх.

2.3.5. Бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, бэлчээрийн даацад үндэслэн тухайн баг, бэлчээр ашиглагчдын хэсгийн бэлчээр нутагт өвөлжих малын тоог гаргаж жил бүрийн 9 дүгээр сарын 1-15-ны дотор сумын Засаг даргад хүргүүлнэ.

2.3.6. Багийн Засаг дарга, бэлчээрийн менежментийн ажлын хэсэгтэй хамтран тус багийн иргэдийн Нийтийн Хурлаар энэ журмын 2.3.5-д заасан малын тоо, Бэлчээр ашиглагчдын хэсэг, нөхөрлөлүүдийн саналд тулгуурлан дараа жилийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хэлэлцүүлж сумын Засаг даргад хүргүүлнэ.

2.3.7. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д заасны дагуу Сумын Засаг даргын Тамгын газрын бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, газрын даамал хамтран баг бүрийн иргэдийн Нийтийн Хурлаар батлагдсан бэлчээрийн ашиглалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэж Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө /цаашид СГЗБТЖТ гэх/-нд тусган жил бүрийн 12 сард багтаан батлуулна.

ГУРАВ. Бэлчээр ашиглалтын хуваарийг зохицуулах:

3.1. Бэлчээр ашиглалтыг тухайн сумын бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн байдал болон фотомониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, тодорхой хугацаагаар төлөвлөх зарчмаар зохицуулна.

3.2. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглах гэрээ /цаашид БАГ гэх/-ний үндсэн дээр талуудын хүлээх үүргийн дагуу ашиглах ерөнхий зохицуулалтыг баримтална.

3.3. Зуслан, намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу өрх, хот айлаар, нөхөрлөлөөр зүй зохистой ашиглана. Нийтээр ашиглах бэлчээрт өөр аймаг, сумын малыг сумын Засаг даргын зөвшөөрөлгүйгээр оруулахыг хориглоно.

3.4. Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрт мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг хоёр хоногоос илүүгүй байлгана.

3.5. Өвөлжөө, хаваржааны бэлчээрээс багийн ИНХ-аас тогтоосон хугацаанд бүх өрх /тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө тусгана/ нүүж малаас бүрэн чөлөөлнө.

3.6. Отрын болон хадлангийн бүс нутагт буухыг хориглоно./Тухайн жилийн Багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ/

3.7. Улирлаар ашиглах бэлчээрээс нүүх, буух хугацааг газарзүйн онцлог ба цаг агаарын нөхцөлөөс хамааруулан өөрчилж болох бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн тухайн улирал, жилд мөрдөгдөнө.

ДӨРӨВ. Бэлчээрийн төлөв байдлыг хянах, даац тогтоох

4.1. Бэлчээрийн төлөвлөлт, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын үр нөлөөг жил бүр фото мониторингийн үр дүнгээр үнэлнэ.

4.2. Бэлчээрийн төлөв байдлыг үнэлж, ургац тооцохдоо улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэг дээр тогтсон аргачлалыг баримтлан гүйцэтгэнэ.

4.3. Мониторингийн цэгийг сонгохдоо бэлчээр ашиглалтын хэсэг бүрээр улирлын бэлчээр болон бэлчээрийн нийтлэг хэв шинжийг төлөөлөх чадварыг нь харгалзан тогтоох ба энэ ажилд бэлчээр ашиглагчдын хэсгийн малчид, нөхөрлөлийн төлөөллийг заавал оролцуулна.

4.4. Мониторингийн цэгийн байршлыг Засаг даргын захирамжаар баталгаажуулж сумын бэлчээр ашиглалтын зурагт нэг бүрчлэн тэмдэглэнэ.

4.5. Фотомониторингийн үр дүнд тулгуурласан тайлан дүгнэлтийг малчдад танилцуулах ажлыг Бэлчээрийн менежментийн ажлын хэсэг хариуцан зохион байгуулна.

4.6. Тухайн сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч иргэн, нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг болон төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй хамтран бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөөг боловсруулах бөгөөд баг, сумын Засаг дарга хэрэгжилтэд хяналт тавина.

ТАВ. Журмыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт:

5.1. Малын тоо толгойн албан татварыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тогтоолд заасан хувь хэмжээгээр тооцож орон нутгийн төсөвт малчин, мал бүхий этгээд тушаана.

5.2. Дараа жилийн татварын хувь хэмжээг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн өөрчлөн баталж болно.

5.3. Олон улсын төсөл хөтөлбөр, иргэдийн хандив.

5.4. Орон нутгийг хөгжүүлэх сан

5.5. Бусад аймаг сумдаас отор, нүүдлээр орж ирсэн малд энэ журмын 5,1-д зааснаар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан татварын хувь хэмжээг 2 дахин нэмэгдүүлэн тооцож татвар ноогдуулан сумын төсөвт төвлөрүүлж тухайн газар нутгийг гэрээнд заасан хугацаанаас хэтрэхгүйгээр чөлөөлүүлнэ.

5.6. Гадны аймаг, сумдаас отроор орж ирсэн малаас авах татварт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчлэхгүй.

5.7. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8 дахь хэсэгт заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн дараах зүйлд зарцуулна.

5.7.1. Бэлчээрийн менежментийг сайжруулах,

5.7.2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх,

5.7.3. Малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх,

5.7.4. Малын чанарыг сайжруулах,

5.7.5. Гэмт халдлага, гамшгаас хамгаалах,

5.7.6. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх,

5.7.7. Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх,

5.7.8. Байгаль орчныг хамгаалах,

5.7.9. Хортон мэрэгчидтэй тэмцэх,

5.7.10. Малчид, нөхөрлөлүүдэд зориулсан сургалт, сурталчилгаа,

5.7.11. Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийн ажиллах зардал

5.7.12. Бэлчээрийг сэргээх сайн туршлага, арга хэмжээг хэрэгжүүлсэн нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэгт урамшуулал олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

ЗУРГАА . Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг:

6.1. Сумын малчин, мал бүхий иргэд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй.

6.1.1. Бэлчээрийн даацад тохирсон малыг өсгөн үржүүлэх, ашиг шим сайтай үүлдрийн малаар сүргийг сэлбэх;

6.1.2. Нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг, багийн бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулах, бэлчээрийн төлөв байдал, даацын фотомониторингийн дүн мэдээний мэдээлэлтэй байх ;

6.1.3. Бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гарсан шийдвэрийг дагаж биелүүлэх;

6.1.4. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгасан өвөлжөө хаваржааны эзэмшиж буй бэлчээрээс өөр бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх,

6.1.5. Дур мэдэн өвөлжөө, хаваржааны хашаа хороо шинээр барихгүй, зарж худалдахгүй байх; /тухайн БАГ, бэлчээр ашиглагчдын хэсэг, нөхөрлөлийн хурлаар хэлэлцүүлж зөвшөөрөл авсан байх/

6.1.6. Бэлчээр, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, тухай бүр цэвэрлэх;

6.1.7. Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, цөлжсөн бэлчээр хамгаалах сайжруулахаас бусад зорилгоор бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх

6.1.8. Энэ журмын 5.4-т заасан сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал гаргах, уг арга хэмжээний явц, гүйцэтгэлд болон сангийн зарцуулалтын байдалд хяналт тавих.

6.2. Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1-т заасны дагуу зохион байгуулалтад орсон бэлчээр ашиглагчдын хэсэг, нөхөрлөл нь сумын Засаг даргатай бэлчээрийг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу гэрээ (цаашид “бэлчээр ашиглалтын гэрээ” гэх)-гээр ашиглаж болно.

6.3. Малчин, мал бүхий этгээд нь энэ журмын 5.1. дэх хэсэгт заасан малын тоо толгойн албан татварыг төлөх, орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх

6.4. Өвөлжөө, хаваржааны бэлчээр, хашаа хороо, худаг уст цэгт өөр аймаг, сум дүүргийн малыг дур мэдэн оруулах, бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, худалдаалахыг хориглоно.

6.5. Бэлчээр ашиглалтын гэрээг жил бүр дүгнүүлээгүй, өвөлжөө, хаваржааны газрыг гэрээнд зааснаар ашиглаагүй бусдад худалдсан, түрээсэлсэн, сумын Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээгүйгээр гадны аймаг, сумдаас отроор айл

буулгасан бол сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах гэрчилгээг цуцлах арга хэмжээ авна.

ДОЛОО. Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг:

7.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1. Сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх;

7.1.2. Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон хагас суурин мал аж ахуй, бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавхи, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох .

7.1.3. Малын тоо, толгойн татварын хувь хэмжээг тогтоох

7.1.4. Сумын тухайн жилийн төсөвт малын тоо толгойн татвараас орсон орлогыг энэ журмын 5.7-д заасан зүйлд зарцуулахаар тусгаж батлах, хэрэгжилтэд хяналт тавих

7.2. Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.2.1. Жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх;

7.2.2. Малын тоо толгойн татварын орлогоос бүрдсэн сангийн хөрөнгөөр тухайн жилд хийж гүйцэтгэх арга хэмжээний саналыг хэлэлцэж батлах;

7.2.3. Бэлчээрт усан хангамжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн дэд бүтцийг сайжруулах саналыг сумын Засаг даргад уламжлах.

7.2.4. Бэлчээрийн даацыг фотомониторингийн аргаар тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдыг татан оролцуулах;

7.2.5. Малын тоо толгойн татварын орлогоос сан бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих, малчдад тайлагнах

7.3. Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.3.1. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн ургац, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох;

7.3.2. Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

7.3.3. Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох,

7.3.4. Энэ журмын хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг, малчин, мал бүхий өрхийг давуу эрхээр улсын төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төв, орон нутгийн төрийн байгууллагын шагналд тодорхойлох.

7.3.5. Гол, горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээр хашихыг хориглох арга хэмжээ авах, бусад тохиолдолд холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

7.3.6. Нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах, бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгоход туслах;

7.3.7. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэг, малчдын оролцоотой зохион байгуулах.

7.3.8. Өвөлжөө, худаг уст цэгийн байршлыг шийдвэрлэх.

7.3.9. Бэлчээрийн төлөв байдал, даацыг тодорхойлох фото-мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жил жилийн мэдээ цуглуулах, үр дүнг хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх.

7.3.10. Малын тоо толгойн татварын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт-үнэлгээ хийх.

7.4. Сумын газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.4.1. Сумын бэлчээрийн зориулалт, түүний хэмжээ, байршлыг зураглан сумын газрын мэдээллийн санд бүртгэх

7.4.2. Сумын Засаг даргын нөхөрлөл, бэлчээр ашиглагчдын хэсэгтэй байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээг бүртгэх, гэрээг сумын газрын мэдээллийн нэгдсэн санд оруулах, батламжийг хэвлэх.

7.4.3. Жил бүр тогтсон хугацаанд тогтсон цэгүүд дээр фотомониторингийн мэдээлэл цуглуулах, орон нутгийн удирдлага, малчдыг бэлчээрийн тухайн жилийн төлөв байдал, даацын мэдээллээр хангах,

7.4.4. Бэлчээрийн фотомониторингийн дүнд үндэслэн бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг үнэлэх, дүнг санд оруулах.

7.4.5. Энэ журмын 7.3.8-т заасан өвөлжөө, худаг, уст цэгийн байршлыг сумын газрын мэдээллийн санд оруулах, тогтмол шинэчлэх.

7.4.6. Фотомониторингийн аргачлалын дагуу буулгасан зурган мэдээлэлд боловсруулалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, даацын мэдээ гаргах ажлыг сумын газрын даамал гүйцэтгэнэ.

7.4.7. Фотомониторингийн дүнг үндэслэн орон нутгийн удирдлага, Бэлчээрийн менежментийн ажлын хэсэг, малчдад зориулсан тайлан, мэдээ гаргах ажлыг сумын бэлчээрийн мэргэжилтэн, газрын даамал хариуцна.

7.5. Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.5.1. Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

7.5.2. Нөхөрлөл, БАХ-н бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

7.5.3. Гэрээг бэлчээрт гаднаас зөвшөөрөлгүйгээр орж ирсэн малыг гаргах

НАЙМ. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх:

8.1. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10-т заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга энэхүү журмыг үндэслэн шийдвэрлэнэ.

8.2. Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

8.3. Гамшиг, асулт үзэгдэл, ослын улмаас өөр аймаг, сумаас малчид нүүдэллэж ирэх шаардлага гарвал тухайн сумын Засаг даргатай уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл уг асуудлыг дээд шатны Засаг дарга нар эсвэл Засгийн газраар шийдвэрлүүлнэ.

8.4. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд заасан хугацаанд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөөгүй малчинд торгууль ногдуулан сумын төсөвт 07 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлнэ.

ЕС. Журам хүчин төгөлдөр болох:

9.1. Энэхүү журмыг захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.